

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар: 19

Улаанбаатар хот

Давхар даатгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 21 дүгээр зүйлийн 21.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 107/53 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.2, 2.3, 2.4, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-иас ирүүлсэн саналыг харгалзан малын индексжүүлсэн даатгалын дунд болон дээд түвшний эрсдэлийн дээд хэмжээнээс давсан эрсдэлийн хариуцлагыг “СКОР” (SCOR) олон улсын давхар даатгагчид давхар даатгуулсугай.

2. Малын индексжүүлсэн даатгалын дунд болон дээд түвшний эрсдэлийг даатгуулах 2023 оны давхар даатгалын гэрээг СКОР (SCOR) олон улсын давхар даатгагчтай байгуулж, давхар даатгалын хураамж 1,251,573,724.35 (нэг тэрбум хоёр зуун тавин нэгэн сая таван зуун далан гурван мянга долоон зуун хорин дөрвөн төгрөг гучин таван мөнгө) төгрөгийг шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д зөвшөөрсүгэй.

3. Олон улсын давхар даатгагчид давхар даатгуулах ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, энэ талаарх холбогдох баримт бичгийг шилэн данс болон санхүү, нягтлан бодох бүртгэлд тусгаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ